



**МОНГОЛЫН УНАГАН БАЙГАЛИЙН ХҮЛЦЭЛ, ТОГТВОРЖИЛТЫГ ХАНГАХ НЬ ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ЗАВХАН АЙМГИЙН ИХ УУЛ, ТОСОНЦЭНГЭЛ СУМ БУЮУ ТАРВАГАТАЙН НУРУУНЫ УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР БОЛОН АРХАНГАЙ АЙМГИЙН АЙМГИЙН БАТЦЭНГЭЛ, ХАЙРХАН СУМДЫН НУТАГ БУЮУ БӨХӨН ШАРЫН НУРУУНД МОНГОЛ ТАРВАГА *MARMOTA SIBIRICA* СЭРГЭЭН НУТАГШУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР**

2023 оны .... сарын ....-ны өдөр

Улаанбаатар хот

1	Үндэслэл	<p>Даян дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн газартай хамтран "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь" МОН/19/301 төслийг Архангай аймгийн Батцэнгэл, Өлзийт, Хайрхан, Эрдэнэмандал сум, Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл сум, Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан, Шинэжинст, Говь-Алтай аймгийн Цогт, Чандмань, Эрдэнэ сумдад 2019-2025 оны хооронд хэрэгжүүлж байна.</p> <p>Тус төсөл нь Саян, Хангайн уулс болон өмнийн говийн бүс нутагт бэлчээр, ойн нөөцийн доройтлыг бууруулах, биологийн олон янз байдлыг тогтвортой хамгаалах, өрхийн амьжиргааг дээшлүүлэх замаар экосистемийн үйлчилгээг сайжруулах зорилготой. Төслийн хүрээнд биологийн олон янз байдал, бэлчээр болон ойн тогтвортой менежменттэй холбоотой эрх зүйн орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, ногоон хөгжлийн бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх, байгалийн баялаг ашигласны төлбөрийг зөв зохистой зарцуулах, хувийн хэвшлийнхний оролцоог дэмжих, Монгол улсад болон олон улсад нэн ховордсон, устах аюулд орж буй биологийн олон янз байдлыг хамгаалах зорилго бүхий түншлэлийг бэхжүүлэх, экосистемийн үйлчилгээг өргөжүүлэх санхүүгийн шинэлэг механизмыг бий болгох, орон нутгийн чадавхыг дэмжих зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p> <p>Бэлчээр, ой, биологийн олон янз байдал нөхөн сэргээгдэж, нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ нэмэгдэнэ. Гол үр дүн нь 300,000 га бэлчээр, 20,000 га тайган ой, 25,000 га заган ойн доройтол буурч, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 0.94 сая га-аар нэмэгдэн, дэлхийн хэмжээнд устах аюулд өртөөд буй биологийн олон янз байдалд учрах аюул буурсан байх юм. Биологийн олон янз байдлыг хамгаалах болон ногоон хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэгдсэн санхүүгийн шинэлэг механизмыг орон нутаг ажил хэрэг болгоход дэмжлэг үзүүлнэ. Үүний зэрэгцээ нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах замаар биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээг сэргээх, тогтвортой байдлыг нь хангана.</p>
---	----------	---

		Тухайлбал, бэлчээр ашиглагчид болон ойн нөхөрлөлүүдийн ногоон хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх, малын тоо толгойг бэлчээрийн даацтай уялдуулах, ойн зохистой ашиглалт, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх малчдын орлого нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлснээр олон нийтэд түшиглэсэн бүлгүүд бэхжиж, иргэдийн амьжиргаа илүү тогтвортой болж, төр-хувийн хэвшлийн түншлэл өргөжин, ногоон хөгжлийн арга замын талаарх олон нийтийн ойлголт нэмэгдсэн байх юм.
2	<b>Зорилго</b>	Төслийн зорилтот бүс нутаг буюу Бөхөн шарын нуруу, Тарвагатайн нуруунд нийт 80 толгой монгол тарвагыг сэлгэн нутагшуулж, биологийн олон янз байдлыг нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах, байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг дэмжих, чадавхжуулах
3	<b>Зорилт</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл сумдын нутаг дэвсгэр буюу Тарвагатайн нурууны улсын тусгай хамгаалалттай газарт 40 толгой монгол тарвага сэргээн нутагшуулан, нутгийн иргэдийн оролцоотой хамгаалан, тоо толгойг нэмэгдүүлэх;</li> <li>• Архангай аймгийн Батцэнгэл /Улаан чулуут баг/, Хайрхан сумдын нутаг /Жарантай баг/ буюу Бөхөн шарын нуруунд 40 толгой монгол тарвага сэргээн нутагшуулан, нутгийн иргэдийн оролцоотой хамгаалан тоо толгойг нэмэгдүүлэх;</li> </ul>
4	<b>Гүйцэтгэх ажил</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Монгол тарвагыг сэргээн нутагшуулахад мөрдөх хууль, эрхзүйн асуудлыг нарийвчлан судалж, шаардлагатай зөвшөөрөл, аргазүй болон бусад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг гарган, бүрдүүлэх; (тарвага сэргээн нутагшуулах шинжлэх ухааны байгууллагын баталсан арга зүй болон IUCN (Олон улсын байгаль хамгаалах холбоо)-ы зэрлэг амьтан сэлгэн нутагшуулах гарын авлагыг мөрдлөг болгох);</li> <li>• Тарвага нутагшуулсан ажлын туршлага, анхаарах хүчин зүйлс, тэдгээр туршилтуудын өнөөгийн байдлын талаарх тайлан мэдээллийг цуглуулж дүгнэлт, санал боловсруулах;</li> <li>• Төслийн зорилтот нутагт Монгол тарвага сэргээн нутагшуулахаар сонгосон газруудаас сэргээн нутагшуулах тохиромжтой бүс нутгийг сонгон идэш тэжээл, ус, хөрс, ерөнхий болон бичил цаг уурын нөхцөл, ургамалжилт болон тарваганы дош, бусад хүчин зүйлсийг нарийвчлан тогтоон газарзүйн мэдээллийн систем ашиглан зураглал үйлдэх;</li> <li>• Монгол тарваганы нөөц бүхий газруудаас сонгож төслийн зорилтот бүс нутаг буюу Завхан аймгийн Их-Уул сум, Зарт багийн нутагт, Тосонцэнгэл сум, Рашаант багт хамрагдах нутаг буюу Тарвагатайн нурууны Улсын тусгай хамгаалалттай газарт тус бүр 20 толгой монгол тарвагыг сэргээн нутагшуулах;</li> <li>• Монгол тарваганы нөөц бүхий газруудаас сонгож төслийн зорилтот бүс нутаг буюу Архангай аймгийн Батцэнгэл /Улаан чулуут баг/, Хайрхан сумдын нутаг /Жарантай баг/ буюу Бөхөн шарын нуруунд тус бүр 20 толгой монгол тарвага сэргээн нутагшуулах;</li> <li>• Орон нутгийн байгаль хамгаалах чиглэлээр ажилладаг нөхөрлөлийн гишүүдэд Монгол тарваганы биологийн онцлог, амьдрах орчны талаар сургалт зохион байгуулж цаашид нутагшуулсан тарвагыг хэрхэн нутгийн иргэдийн оролцоотой хамгаалах талаар санал боловсруулах;</li> <li>• Сэргээн нутагшуулсан тарвагыг орон нутгийн байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг малчдын</li> </ul>




		нөхөрлөл (шаардлагатай бол шинээр байгуулах) болон холбогдох байгууллагуудад төсөл хэрэгжүүлэх нэгжтэй санал солилцон хүлээлгэн өгч хариуцуулах;
5	<b>Хамрах газар нутаг</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл сумдын нутаг буюу Тарвагатайн нурууны улсын тусгай хамгаалалттай газар;</li> <li>• Архангай аймгийн Батцэнгэл /Улаан чулуут баг/, Хайрхан сумдын нутаг /Жарантай баг/ буюу Бөхөн шарын нуруу;</li> </ul>
6	<b>Хүлээлгэж өгөх ажлын үр дүн</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Завхан аймгийн Их-Уул, Тосонцэнгэл сумдын нутаг буюу Тарвагатайн нурууны улсын тусгай хамгаалалттай газарт монгол тарвага сэргээн нутагшуулсан ажлын тайлан, холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн акт болон сургалт зохион байгуулсан талаархи тайлан</li> <li>• Архангай аймгийн Батцэнгэл, Хайрхан сумдын нутаг буюу Бөхөн шарын нуруунд монгол тарвага сэргээн нутагшуулсан ажлын тайлан, холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн акт болон сургалт зохион байгуулсан талаархи тайлан</li> <li>• Төслийн зорилтот нутаг дэвсгэрт нийт 80 толгой тарвагыг сэргээн нутагшуулсан байна.</li> <li>• Гэрээний хүрээнд зохион байгуулсан сургалт, зөвлөгөөн, чадавхжуулах арга хэмжээ, уулзалтанд хамрагдсан оролцогчдын бүртгэлийг төслөөс гаргасан эксел файлын маягт дээр хийж, оролцогчдын гарын үсэг зурсан баримтын хамт тайланд давхар хавсарган хүлээлгэж өгнө.</li> </ul>
7	<b>Ажил гүйцэтгэх хугацаа, тайлангийн бүрдэл, зохион байгуулалт</b>	<p>Ажил эхлэх хугацаа: 2023 оны 06 сарын 26-ны өдөр</p> <p>Ажил дуусах хугацаа: 2022 оны 09 сарын 30-ны өдөр</p> <p>2023 оны 07 сарын 05-ны өдөр эхлэлийн тайлан. /40%/</p> <ul style="list-style-type: none"> <li>• Ажил гүйцэтгэх аргачлал, ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж, захиалагч талаар баталгаажуулах;</li> </ul> <p>2023 оны 07 сарын 30-ны өдөр явцын тайлан. /30%/</p> <ul style="list-style-type: none"> <li>• Сэргээн нутагшуулж буй монгол тарвагын зан төрх болон мониторинг судалгааны мэдээлэл, арга зүй, аргачлал болон орон нутгийн байгаль хамгаалах чиглэлээр ажилладаг нөхөрлөлийн гишүүдэд сургалт зохион байгуулсан тухай тайлан;</li> </ul> <p>2023 оны 08 сарын 30-ны өдөр эцсийн тайлан /30%/</p> <ul style="list-style-type: none"> <li>• Зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэсэн хугацаанд боловсруулсан төлөвлөгөө, тайлан, гарын авлага, баримт бичгийг хавсарган гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлантай хамт захиалагч талд хүлээлгэн өгөх;</li> </ul> <p>Шалгарсан байгууллага нь төсөл хэрэгжүүлэгч нэгж, НҮБХХ-ийн газар болон бусад холбогдох төв, орон нутгийн түвшний оролцогч талуудтай нягт хамтран ажиллана. Зөвлөх нь учирч болзошгүй эрсдлийг цаг хугацаанд нь олж тогтоох үүнээс үүдэн үйлчилгээ үзүүлэх хугацаа ямар нэгэн байдлаар хэтрэхээр бол энэ тухай урьдчилан мэдэгдэж ажиллана</p>
8	<b>Ажил гүйцэтгэх багт тавих шалгуур</b>	<ul style="list-style-type: none"> <li>• Байгаль орчны чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгэдэг амьтан сэргээн нутагшуулах эрх бүхий төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ судалгааны байгууллага байх;</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>• Амьтан, ургамлын тархалт, полуляци, байгаль орчны менежмент, ТХГН-ын чиглэлээр орон нутгийн иргэдийг оролцуулан хээрийн тооллого судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн туршлагатай байх /багийн гишүүд нь сүүлийн 3 жилд хамгийн багадаа нэг ажлыг хийж гүйцэтгэсэн байх/;</li> <li>• Төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил, орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж, тэдгээрийн оролцоотой олон нийтэд суурилсан байгаль хамгааллын үйл ажиллагааг зохион байгуулах туршлагатай байх;</li> <li>• Нутгийн иргэдийн оролцоог хангасан үйл ажиллагааг зохион байгуулах, тэр дундаа байгаль хамгаалах идэвхийг өрнүүлэх, тэднийг чадавхжуулах үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай байх;</li> <li>• Ижил төстэй 2-оос цөөнгүй ажлыг амжилттай гүйцэтгэсэн байх;</li> <li>• Байгууллага нь 5-6 хүний бүрэлдэхүүнтэй баг байх ба амьтан судлал, БОЯБ-ын хамгаалал, амьдрах орчны зураглал, экологи, ургамлын болон байгалийн нөөцийн менежмент зэрэг чиглэлүүдээр мэргэшсэн байна. Үүнд: Багийн ахлагч: <ul style="list-style-type: none"> <li>○ Биологич болон байгаль орчны чиглэлээр 20-иос дээш жил ажиллаж байсан туршлагатай байх (зохиогчийн эрхтэй бол давуу тал болно);</li> <li>○ Хээрийн судалгааны мэдээлэл цуглуулах болон судалгааны мэдээлэл боловсруулах ажлыг зохион байгуулж байсан туршлагатай байх;</li> </ul> </li> </ul> <p>Судлаачид (2-3 судлаач):</p> <ul style="list-style-type: none"> <li>○ Амьтан судлаач нь 5-аас дээш жил амьтан, ургамлын хээрийн судалгаа хийж байсан туршлагатай байх (өмнө нь тарвага сэргээн нутагшуулж байсан туршлагатай бол давуу тал болно);</li> <li>○ Хээрийн тооллого судалгааны ажил гүйцэтгэх, лабораторийн нөхцөлд мэдээлэл боловсруулах туршлагатай байх;</li> <li>○ Биологи, амьтан судлалын чиглэлээр магистр зэрэгтэй байх (PhD доктор зэрэг хамгаалсан бол давуу тал болно);</li> <li>○ ArcGIS/QGIS болон R зэрэг газарзүйн мэдээллийн системийн программууд дээр орон зайн мэдээлэл боловсруулах чадвартай байна.</li> </ul>
9	<b>Мэдээллийн нууцлал ба үр дүн</b>	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны баталгаажсан албан бичгийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно. Зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд боловсруулсан судалгаа, төлөвлөгөө, тайлан зэрэг баримт бичиг нь захиалагч талын өмч байна.
10	<b>Захиалагч байгууллага</b>	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн хамтран хэрэгжүүлж буй "Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь" төсөл
11	<b>Гүйцэтгэх ажлын төсөв</b>	69,400,000 (жаран ёсөн сая дөрвөн зуун мянга) төгрөг

Танилцсан:

Хянасан:

Боловсруулсан:

  
DocuSigned by:  
  
DocuSigned by: 09D78ACADA164DF...  
  
227073394022416...

Ц.УРАНЧИМЭГ /Төслийн захирал/

Б.ЭРДЭНЭБИЛЭГ /Төслийн зохицуулагч/

А.БАЯСГАЛАН /ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ/

**Хавсралт 1. Шалгаруулах үзүүлэлтүүд**

Шалгуур	Оноо
<b>Техникийн шалгуур 1: Байгууллагын үнэлгээ</b>	<b>30</b>
<ul style="list-style-type: none"> <li>Байгаль орчны чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгэдэг амьтан сэргээн нутагшуулах эрх бүхий төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээ судалгааны байгууллага байх;</li> <li>Амьтан, ургамлын тархалт, полуляци, байгаль орчны менежмент, ТХГН-ын чиглэлээр орон нутгийн иргэдийг оролцуулан хээрийн тооллого судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн туршлагатай байх /багийн гишүүд нь сүүлийн 3 жилд хамгийн багадаа ижил төстэй ажлыг хийж гүйцэтгэсэн байх/;</li> <li>Төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил, орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж, тэдгээрийн оролцоотой олон нийтэд суурилсан байгаль хамгааллын үйл ажиллагааг зохион байгуулах туршлагатай байх;</li> <li>Нутгийн иргэдийн оролцоог хангасан үйл ажиллагааг зохион байгуулах, тэр дундаа байгаль хамгаалах идэвхийг өрнүүлэх, тэднийг чадавхжуулах үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай байх;</li> </ul>	15
<ul style="list-style-type: none"> <li>Ижил төстэй 2-оос цөөнгүй ажлыг амжилттай гүйцэтгэсэн байх;</li> </ul>	15
<b>Техникийн шалгуур 2: Судалгааны багийн үнэлгээ</b>	<b>40</b>
<p>Судалгааны багийн ахлагч-1:</p> <ul style="list-style-type: none"> <li>Биологич болон байгаль орчны чиглэлээр 20-иос дээш жил ажиллаж байсан туршлагатай байх (зохиогчийн эрхтэй бол давуу тал болно);</li> <li>Хээрийн судалгааны мэдээлэл цуглуулах болон судалгааны мэдээлэл боловсруулах ажлыг зохион байгуулж байсан туршлагатай байх;</li> </ul>	20
<p>Судлаачид (2-3 судлаач):</p> <ul style="list-style-type: none"> <li>Амьтан судлаач нь 5-аас дээш жил амьтан, ургамлын хээрийн судалгаа хийж байсан туршлагатай байх (өмнө нь тарвага сэргээн нутагшуулж байсан туршлагатай бол давуу тал болно);</li> <li>Хээрийн тооллого судалгааны ажил гүйцэтгэх, лабораторийн нөхцөлд мэдээлэл боловсруулах туршлагатай байх;</li> <li>Биологи, амьтан судлалын чиглэлээр магистр зэрэгтэй байх (PhD доктор зэрэг хамгаалсан бол давуу тал болно);</li> <li>ArcGIS/QGIS болон R зэрэг газарзүйн мэдээллийн системийн программууд дээр орон зайн мэдээлэл боловсруулах чадвартай байна;</li> </ul>	20
<b>Техникийн шалгуур 3: Судалгааны төслийн аргазүй, төлөвлөлтийн үнэлгээ</b>	<b>30</b>
<ul style="list-style-type: none"> <li>Зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгэх аргачлал, төлөвлөгөө;</li> </ul>	30
<b>Техникийн шалгуурын нийт оноо</b>	<b>100</b>
<b>Авбал зохих техникийн доод оноо</b>	<b>70</b>